БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

З.БУЯНТ

2024 оны 09 дугаар сарын 19-ны өдөр

**БУЯНТ-УХАА 2 ХОРООЛОЛД ТОГЛООМЫН ТАЛБАЙН ЗАСВАР (21 ДҮГЭЭР ХОРОО) АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| **1** | Төсөл боловсруулах үндэслэл | - Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 05-ны 16 дугаар тогтоол. |
| **2** | Байршил, эдэлбэр газрын хэмжээ | - Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа 2 хороололд тоглоомын талбай |
| **3** | Зориулалт хүчин чадал | - Тохижилт бүхий хүүхдийн тоглоомын талбай байгуулах |
| **4** | Төсөл гүйцэтгэх хугацаа | - Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно. |
| **5** | Төслийн захиалагч | - Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| **6** | Төсөл гүйцэтгэх байгууллага | - Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах, гадна тохижилтын ажил гүйцэтгэх эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой . |
| **7** | Ажил гүйцэтгэх үе шат | - Талбайн судалгаа, хэмжилтийг илүү дэлгэрэнгүй хийх.<br>- Хорооны Засаг даргатай зөвшилцсөний дараа ажлын тоо хэмжээг захиалагчид танилцуулах.<br>- Загвар зураг боловсруулах /Нүүр хуудас батлагдаж магадлал хийгдсэн байх/.<br>- Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. /магадлал хийгдсэн байх/.<br>- Төсөвт өртөг /магадлал хийгдсэн байх/. |
| **8** | Орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага | - Архитектур орон зай төлөвлөлтийг тус байршлын онцлог, шаардлага, орц гарц, орчны ерөнхий төлөвлөгөөтэй тохижилтын шийдэл гаргах.<br>**<u>Тоглоомын талбай:</u>**<br>- Тоглоомын талбайн стандарт болон норм, норматив MNS ISO8124-1:2011, MNS ISO8124- |

| | | |
|---|---|---|
| | | 2:2011, MNS ISO8124-3:2011, MNS ISO8124-4:2011 мөрдөх. (Судалж үзэх)<br>- Тоглоомын талбайн доод талыг EPDM-ээр төлөвлөх.<br>**Ногоон байгууламж:**<br>- Одоо байгаа мод, бут, сөөгийг гэмтээхгүй шинээр Монгол орны уур амьсгалд тохирсон шилмүүст болон навчит мод, бут, сөөг, зүлэг тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.<br>- Ногоон байгууламжийг хамгаалсан хайс төлөвлөх. (модон шонтой)<br>**Явган зам, талбай:**<br>- Зорчигчдын амрах талбай болон хүний хөдөлгөөнийг салгаж зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулах орц гарцыг нэмэгдүүлж төлөвлөх.<br>- Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009 стандарт.<br>**Бусад**<br>- Гадна гэрэлтүүлгийг орчин үеийн загвартай эрчим хүчинд хэмнэлттэй гэрэлтүүлэг шинээр төлөвлөх. |
| **9** | Төсөл боловсруулахад ашиглах материал | **Монгол Улсын хуулиуд**<br>- Хот байгуулалтын тухай хууль<br>- Барилгын тухай хууль<br>- Газрын тухай хууль<br>- Усны тухай хууль<br>- Бусад холбогдох хууль<br>**Норм, нормативууд:**<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД30-01-04/<br>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНбД 3.01-06-90/<br>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм<br>- Бусад холбогдох норм, дүрэм |
| **10** | Эдийн засгийн тооцоо, төсөв | - Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох. |
| **11** | Онцгой шаардлага | - Ажил эхлэх үед холбогдох хүмүүст мэдэгдэж хийгдэх ажлын дараалал, хугацааг тодорхой болгож мэдээллэнэ.<br>- Төсвийг зохиохдоо заавал ажлын талбарт очиж, хэмжилт хийн фото зургаар баталгаажуулах<br>- Тохижилтын стандарт мөрдөн төлөвлөх.<br>- Улаанбаатар хотын "Нэг хот, Нэг стандарт"-ын эмхэтгэл болох UCS стандартуудыг мөрдөж ажиллах.<br>- Иж бүрэн гудамж: Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэгцээ /UCS0001-02:2019/ |

| | | |
|---|---|---|
| | | - Иж бүрэн гудамж: Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага /UCS0901B:2020/ |

- Зураг төсвийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, зориулалтыг өөрчлөхгүйгээр төсөвт өртөгт багтаах. Төсөвт өртөг хэтэрсэн тохиолдолд ажлын зураг батлагдахгүй болно.
- Зураг төсвийн болон ажил гүйцэтгэх явцад хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг хатуу мөрдөж ажиллах.
- Эрүүл аюулгүй, чанарын шаардлага хангасан материал сонгох /БНбД-д заасан/. Зөвшөөрөгдсөн лаборатори, гарал үүслийн, сертификаттай баталгаат материалыг ашиглах.

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ЛУВСАНЖАМЪЯН

**21 ДҮГЭЭР ХОРОО, Буянт-Ухаа 2 хороолол – 3 байршил**

